

БИЗКОН АУДИТ

АУДИТЫН ТАЙЛАН

“БАЯН ТЭС ФИНАНС ББСБ” ХХК

2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон

Санхүүгийн Тайлан

Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт

УЛААНБААТАР

2026 он

БИЗКОН АУДИТ ХХК

АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

2025 он 3 сар 30 өдөр

Дугаар ^{СД} 37/26

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БАЯН ТЭС ФИНАНС ББСБ” ХХК-ийн удирдлагад

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудаас бүрдсэн “БАЯН ТЭС ФИНАНС ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид, “БАЯН ТЭС ФИНАНС ББСБ” ХХК-ийн 2025 оны 12-р сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-уудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ийн дүрэм” гэх)-ийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л. ОТГОНБАЯР

БАЯН ТЭС ФИНАНС ББСБ ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31

(төгрөг)

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	2,736,392,633.11	1,532,034,922.43
Зээл		2,347,287,674.74
Авлага	-	102,555,093.68
Татвар, НДШ-ийн авлага		
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,736,392,633.11	3,981,877,690.85
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,149,000.00	30,112,876.67
Биет бус хөрөнгө	-	10,640,000.00
Эргэлтийн бус хөрөнгө	8,149,000.00	40,752,876.67
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,744,541,633.11	4,022,630,567.52
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	234,552,733.11	125,493,952.13
Цалингийн өглөг	-	3,099,330.50
Татвар, НДШ-н өглөг		6,317,403.80
Бусад богино хугацаат өр төлбөр	-	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	234,552,733.11	134,910,686.43
Нийт өр төлбөрийн дүн	234,552,733.11	134,910,686.43
Эзэмшигчдийн өмч		
Энгийн хувьцаа	2,510,000,000.00	3,500,000,000.00
Хуримтлагдсан ашиг	(11,100.00)	387,719,881.09
Эзэмшигчдийн өмчийн дүн	2,509,988,900.00	3,887,719,881.09
НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	2,744,541,633.11	4,022,630,567.52
	-	-

Хүлээн зөвшөөрсөн:

БАЯН ТЭС ФИНАНС ББСБ ХХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31

(төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны 12-р сарын 31

Зээлийн хүүний орлого	499,210,168.34
Зээлийн хүүгийн зардал	-
Цэвэр зээлийн хүүгийн орлого	499,210,168.34
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	39,951,700.00
Хүүгийн бус зардал	176,173,145.98
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	362,988,722.36
Ердийн бус орлого	27,835,041.07
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	390,823,763.43
Орлогын татварын зардал	3,092,782.34
Цэвэр ашиг/алдагдал	387,730,981.09

Хүлээн зөвшөөрсөн:

2 БИЭКОН АУДИТ

БАЯН ТЭС ФИНАНС ББСБ ХХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 оны 12 дугаар сарын 31

(төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,510,000,000.00	-	(11,100.00)	2,509,988,900.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	2,510,000,000.00	-	(11,100.00)	2,509,988,900.00
Тайлангийн хугацааны ашиг (алдагдал)			387,730,981.09	387,730,981.09
Бусад дэлгэрэнгүй орлого			-	-
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт	990,000,000.00		-	990,000,000.00
Зарласан ногдол ашиг			-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-	-
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,500,000,000.00	-	387,719,881.09	3,887,719,881.09

Хүлээн зөвшөөрсөн:

БАЯН ТЭС ФИНАНС ББСБ ХХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2025 оны 12 дугаар сарын 31

(төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 12-р сарын 31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	4,245,620,957.44
Зээлийн үндсэн төлбөрт хүлээн авсан	3,092,019,123.52
Зээлийн хүүгийн төлбөрт	446,232,341.89
Шимтгэл хураамжын орлого	39,951,700.00
Бусад мөнгөн орлого	667,417,792.03
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	5,454,978,668.12
Олгосон зээл	4,439,739,500.00
Ажилчдад олгосон мөнгө	81,567,417.84
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	23,621,620.57
Бусад мөнгөн зарлага	910,050,129.71
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,209,357,710.68)
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-
Хүлээн авсан хүүний орлого	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	170,000,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	-
Бусад мөнгөн зарлага	170,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(170,000,000.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	175,000,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	-
Бусад мөнгөн орлого	175,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-
Торгуулийн зардал	-
Бусад мөнгөн зарлага	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	175,000,000.00
Валютын ханшийн зөрүү	-
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,204,357,710.68)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,736,392,633.11
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,532,034,922.43

Хүлээн зөвшөөрсөн:

4 ВИБЭКОН АУДИТ

1. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1	Байгууллагын нэр:	“БАЯН ТЭС ФИНАНС ББСБ” ХХК
1.2	Улсын бүртгэлийн дугаар:	9015005212
1.3	Регистрын дугаар:	7044593
1.4	Үүсгэн байгуулсан баримт бичиг:	Дүрэм
1.5	Үйл ажиллагааны чиглэл / код/:	<ul style="list-style-type: none">Банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа
1.6	Дүрмийн сан:	3,500,000,000 (Гурван тэр бум таван зуун сая) төгрөг
1.7	Захирал:	Хүдэрболд овогтой Бат-Эрдэнэ
1.8	Гэрчилгээн дээрх хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул, 15-р хороо, стадион оргил, чингисийн өргөн чөлөө, 33/2,1407 тоот
1.9	Үүсгэн байгуулагдсан огноо:	2024 оны 07 дугаар сарын 01-ны өдөр
1.10	Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо:	2024 оны 07 дугаар сарын 04-ны өдөр

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН БАЙДАЛ

Тус компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

Компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн байна.

2.1 Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн аккруэл сууриар бэлтгэсэн.

2.2. Таамаглал, тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ, тооцоолол түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөлөл нь байнга хянаж шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнгүүдэд материаллаг нөлөө үзүүлэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын тодорхой бус асуудлуудыг доор дурьдсан орлогын тодруулгын хэсэгт багтаасан болно.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ өөрийн компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримталдаг бөгөөд бодлогын баримт бичгийг цаашид сайжруулах шаардлага байгаа болно.

3.1. Мөнгө хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга

СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга

НББОУС-32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга

Компанийн касс дахь болон банкны харилцах дансанд байгаа төгрөг, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлсийг мөнгөн хөрөнгөнд хамааруулна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

3.2. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга

НББОУС-16 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн зүйлийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг.

- Хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай.
- Хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой.

Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг дараах зүйлсээс бүрдэнэ.

- Гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татварын дүнг оруулсан худалдааны хөнгөлөлт, буцаалтыг хассаны дараах худалдан авалтын үнэ
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой аливаа шууд зардлууд
- Тухайн зүйлийг олж эзэмших үед эсвэл түүнийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлын анхны тооцоолол.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр үнэлдэг. Бөөн дүнгээр худалдан авсан хөрөнгийн үнийг худалдан авсан хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэд үндэслэн хуваарилдаг. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж үндсэн хөрөнгийг барьж дуустал гарсан зээлийн хүүг капиталжуулах бөгөөд түүнээс хойших гарсан хүүгийн зардлыг капиталжуулахгүй.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилсан хуваарилалт юм. Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг түүний бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоходоо “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн дагуу тооцно.

3.3. Орлогын бүртгэлийн бодлого

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
СТОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө
НББОУС 18 Орлого

Орлого гэдэг нь байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өөрийн капитал болгон өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт, өрийн бууралт хэлбэрээр илэрсэн хөрөнгийг бий болгох буюу нэмэгдүүлж буй эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм.

Орлого хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн ирээдүйн үр ашгийн хэмжигдэж болохуйц өсөлт нь хөрөнгийг нэмэгдүүлэх буюу өр төлбөрийг багасгаж байвал орлого, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрдөг. Орлогыг хүлээн зөвшөөрснөөр хөрөнгийн өсөлт болон өр төлбөрийн бууралтыг нэг зэрэг хүлээн зөвшөөрнө.

3.4. Зардлын бүртгэлийн бодлого

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга

НББОУС 23 Зээлийн өртөг

НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө

Зардал гэдэг нь хөрөнгийг хасагдуулж, элэгдүүлэх хэлбэрээр тайлант үед гарсан эдийн засгийн үр ашгийн бууралт буюу өмч эзэмшигчдэд хуваарилахаас бусад байдлаар өмчийг багасгах, өр төлбөр нэмэгдэхийг хэлнэ. Зардлын тодорхойлолтод байгууллагын үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны явцад үүссэн зардлыг хамааруулна.

Зардлыг хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг баримтлан жинхэнэ хэрэгжилтийн зарчмын дагуу бүртгэлээ хөтлөх тул тэдгээрийг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухайн тайлангийн хугацаанд нь хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана.

Хөрөнгө багасгах буюу өр төлбөр нэмэгдсэний улмаас эдийн засгийн үр өгөөж буурч, улмаар энэ бууралтыг найдвартай хэмжих боломжтой байвал түүнийг орлого, үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрнө. Энэ зардлыг хүлээн зөвшөөрөхдөө өр төлбөрийн өсөлт буюу хөрөнгийн бууралтыг хамтад нь хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Мөн гарсан зардал болон тодорхой зүйлийн өртгийг түүнтэй холбоотой олсон орлогод шууд хамааруулах үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Орлого, зардал зохицох зарчим нь ажил гүйлгээ болон бусад үйл явдлын үр дүнд бий болсон орлого ба зардлыг нэгэн зэрэг хамтад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Үйл ажиллагааны зардал

Байгууллагын ажилтнуудын цалин, нийгмийн даатгал, материал, хангамж, цахилгаан, халаалт, дулаан, цэвэр ба бохир ус, харилцаа холбоо, шатахуун, бичиг хэрэг, томиллолт, элэгдлийн зардлууд зэрэг хамаарна.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

“Нийгмийн даатгалын тухай” хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

2025 оны 12 сарын 31-ны байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Банкин дахь мөнгө	2,736,392,633.11	1,532,034,922.43
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2,736,392,633.11	1,532,034,922.43

2. ЗЭЭЛ, АВЛАГА

2025 оны 12 сарын 31-ны байдлаар зээл болон авлага дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Зээл	-	2,347,287,674.74
Авлага		102,555,093.68
Нийт дүн	-	2,449,842,768.42

3. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

2025 оны 12 сарын 31-ны байдлаар үндсэн хөрөнгө дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Текник хэрэгсэл - компьютер	4,348,000.00	11,456,310.00
Компьютер, дагалдах хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл		(4,546,898.33)
Текник хэрэгсэл-Авто машин		17,900,000.00
Тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл	3,801,000.00	(895,000.00)
Эд хогшил - ширээ сандал		6,780,800.00
Тавилга эд хогшилын хуримтлагдсан элэгдэл		(582,335.00)
Биет бус хөрөнгө		11,400,000.00
Программ хангамжийн хуримтлагдсан хорогдол		(760,000.00)
Нийт үндсэн хөрөнгийн дүн	8,149,000.00	40,752,876.67

4. ДАНСНЫ ӨГЛӨГ, БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

2025 оны 12 сарын 31-ны байдлаар дансны өглөг, бусад богино хугацаат өглөг дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Дансны өглөг	234,552,733.11	125,493,952.13
НДШ-н өглөг		-
Цалингийн өглөг		3,099,330.50
ХХОАТ-н өглөг		6,317,403.80
ААНАОТ-н өглөг		-
Нийт өглөгийн дүн	234,552,733.11	134,910,686.43

5. ЭЗДИЙН ӨМЧ

2025 оны 12 сарын 31-ны байдлаар эзний өмч дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Энгийн хувьцаа	2,510,000,000.00	3,500,000,000.00
Дүн	2,510,000,000.00	3,500,000,000.00

6. ХУРИМТЛАГДСАН АШИГ

2025 оны 12 сарын 31-ны байдлаар хуримтлагдсан ашиг дараах байдалтай байна.

Дансны нэр	2024.12.31	2025.12.31
Хуримтлагдсан ашиг	(11,100.00)	387,719,881.09
Дүн	(11,100.00)	387,719,881.09

7. ОРЛОГО

2025 оны 12 сарын 31-ны байдлаар орлого дараах байдалтай байна.

Дансны нэр	2025.12.31
Хүүний орлого	499,210,168.34
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	39,951,700.00
Нийт орлого	539,161,868.34

8. ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

Тайлант хугацааны хүүгийн бус зардал дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

Дансны нэр	-	2025.12.31
Цалингийн зардал		107,371,449.99
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал		13,421,431.27
Зохицуулалтын үйлчилгээний хураамж		3,000,000.00
Гэрээгээр ажиллагсдын ажлын хөлс		10,000,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ		3,000,000.00
Зар сурталчилгааны зардал		5,563,636.36
Шуудан холбооны зардал		6,240,375.00
Шимтгэлийн зардал		497,995.00
Элэгдэлийн зардал		6,784,233.33
Бичиг хэргийн зардал		6,362,800.00
Бусад зардал Зогсоолын төлбөр		2,060,000.00
Бусад зардал		5,851,225.03
Бусад зардал-fincore программ ашиглалт		6,020,000.00
Нийт дүн	-	176,173,145.98

9. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

2025 оны 12 сарын 31-ны байдлаар орлогын татварын зардал дараах байдалтай байна.

Дансны нэр	-	2025.12.31
Тайлант үеийн орлогын татварын зардал	-	3,092,782.34
Дүн	-	3,092,782.34

10. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

2025 оны 12-р сарын 31-наар бидэнд мэдэгдэж байгаа томоохон зарга, маргаан, нэхэмжлэл үгүй байна. Өөрөөр хэлбэл байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрөхүйц болзошгүй өр төлбөр байхгүй байна.

Гүйцэтгэсэн,

Г. Саран.

Хүлээн зөвшөөрсөн: